


Уур амьсгалын өөрчлөлт ба хүүхдийн эрх

Б.Хишигжаргал


Уур амьсгалын өөрчлөлт, цэвэр агаар хөтөлбөрийн мэргэжилтэн
НҮБ-ын Хүүхдийн сан

Уур амьсгалын өөрчлөлт Монгол улсад




Агаарын дундаж температурын өөрчлөлт

Агаарын дундаж температурын өөрчлөлтийн тархалт




Уур амьсгалын өөрчлөлт Монгол улсад


Жилийн дундаж хур тунадас, 1951-2020, Монгол




Хур тунадасны тархалтын өөрчлөлт, 1951-2020, Монгол



Цэвдэг хайлсаар байна




Монгол орны нийт газар нутгийн 63%-д тасалданги болон алаг цоог хэлбэрийн цэвдэгтэй.



Сүүлийн 40 жилд, цэвдэг нэмүү хайлж байна.

Монгол орны цөлжилт, газрын доройтол



МОНГОЛ УЛСЫН
ГАЗАР НУТГИЙН

76,8%

НЬ ДУНД БОЛОН ХҮЧТЭЙ

**ЦӨЛЖИЛТӨНД
ӨРТЖЭЭ!**

Таних тэмдэг


- ★ Нийслэл
- ⊙ Аймгийн төв
- Гал, мөрөн
- Нуур
- Улсын хил
- Аймгийн хил
- Сумын хил

Цөлжилт/доройтлын зэрэглэл

- Доройтол/цөлжилт үгүй
- Сул доройтсон/цөлжсөн
- Дунд доройтсон/цөлжсөн
- Хүчтэй доройтсон/цөлжсөн
- Нэн хүчтэй доройтсон/цөлжсөн


Уур амьсгалын өөрчлөлтийн хэтийн төлөв Монгол улсад

Projected Average Mean Surface Air Temperature
Mongolia; (Ref. Period: 1995-2014), Multi-Model Ensemble




— Hist. Ref. Per., 1950-2014 — SSP1-1.9
— SSP1-2.6 — SSP2-4.5
— SSP3-7.0 — SSP5-8.5

Projected Precipitation Percent Change
Mongolia; (Ref. Period: 1995-2014), Multi-Model Ensemble



— Hist. Ref. Per., 1950-2014 — SSP1-2.6
— SSP2-4.5 — SSP3-7.0
— SSP5-8.5


Зудын эрсдэлийн зураг 2030 он




Уур амьсгал, байгаль орчны хүүхдэд үзүүлэх эрсдэлийн индекс

Олон талт эрсдэл, салбарыг хамруулсан загвар


Олон эрсдэлийг нэг доор нэгтгэж, хүүхдийн эрүүл мэнд, өсөлт хөгжилд хамааралтай салбаруудад тэнцвэртэй мэдээлэл өгөх зорилготой.



Нэг: Уур амьсгал, байгаль орчны цочир, аюулт үзэгдэлд өртөмтгий байдал




Хоёр: Хүүхдийн эмзэг байдал



Дэлхийн даяар хүүхдийн эрхийн хямралтай нүүр тулж байна.

1 тэрбум хүүхэд

маш өндөр эрсдэлтэй улсуудад амьдарч байна



Бүх хүүхдийн 99%

уур амьсгалын өөрчлөлт, байгалийн аюулт үзэгдэл, цочрол эсвэл бохирдлын аль нэгэнд өртөж байна

Энэ нь



...эрүүл мэндийн хямрал
хүүхдийн 90% нь агаарын бохирдолд
дэлхийн бүх хүүхдийн 1/3 хар тугалганы
бохирдолд өртөж байна.



...усны хямрал
920 сая хүүхэд усны хомсдолд



...хүүхэд хамгааллын хямрал
43 сая хүүхэд цаг агаарын аюулт үзэгдлээс болж
шилжин нүүсэн



...хоол тэжээлийн хямрал
24 сая хүүхэд 2050 он гэхэд уур амьсгалын
хямралаас үүдэлтэй хоол тэжээлийн дутагдалд орох
төлөвтэй



...боловсролын хямрал
38 сая хүүхдийн боловсрол уур амьсгалын
хямралаас болж завсардсан



...хүмүүнлэгийн хямрал
175 сая хүүхэд гамшигт үзэгдэлд өртөх тооцоолол

Уур амьсгалын өөрчлөлт ба хүүхдийн эрх

- Хүүхдийн эрхийн тухай НҮБ-ын конвенц нь дэлхийн улс орнууд хүүхдийн эрхийг сахин хамгаалахаа амласан чухал хэлэлцээр билээ. Хүүхдийн эрхийн тухайн конвенцод хүүхэд гэж хэнийг хэлэх, тэд ямар эрх эдлэх, мөн хүүхдийн эрхийг хамгаалах, дэмжих, ханган биелүүлэхэд төр засаг ямар үүрэг хүлээх ёстойг тайлбарласан байдаг.
- Хүүхдийн Эрхийн Хорооноос Ерөнхий тайлбар №26 нэртэй нэгэн баримт бичиг боловсруулан гаргасан бөгөөд үүнд хүрээлэн буй орчин болон уур амьсгалын өөрчлөлт хүүхдийн эрхтэй ямар холбоотой болохыг, мөн хүүхдийн эрхийг хамгаалахын тулд юу хийх ёстой талаар засгийн газруудад тайлбарлаж өгсөн.

Уур амьсгалын өөрчлөлт ба хүүхдийн эрх

- Хүрээлэн буй орчинд учирч буй хор хөнөөл нь дэлхий нийтийн хүүхдийн эрхэд томоохон аюул учруулж байна. Ийм хүүхдийн эрхийг хамгаалах ёстой.
- Цэвэр, эрүүл, тогтвортой орчинд амьдрах нь хүний эрх бөгөөд хүүхдүүд эрхээ эдлэх зайлшгүй шаардлагатай.
- Ерөнхий тайлбарт хүрээлэн буй орчин, уур амьсгалын талаар яагаад яаралтай арга хэмжээ авах шаардлагатай байгааг, мөн хүүхдийн бүхий л эрхийг хамгаалахын тулд засгийн газрууд юу хийх ёстойг тайлбарлан, төр засаг одоо цаг үеийн төдийгүй ирээдүйн хүүхдүүдийн эрхийг хамгаалах ёстой гэдгийг тодорхой болгосон.

Хүүхдийн эрх нь хүрээлэн буй орчин болон уур амьсгалын өөрчлөлттэй ямар холбоотой вэ?

Хүүхдийн эрх бүгд хоорондоо уялдаа холбоотой бөгөөд бүгд нэгэн адил чухал. Хүрээлэн буй орчинд учирч буй хор хөнөөл болон уур амьсгалын өөрчлөлт хүүхдийн зарим эрхэд нэн их аюул учруулж байна. Зарим эрх нь сурч боловсрох гэх мэт хүүхдийн эрхийг хамгаалахад чухал үүрэг гүйцэтгэдэг.



2-р зүйл

Ялгаварлан гадуурхах явдалд өртөхгүй байх эрх

Хүрээлэн буй орчинд учирч буй хор хөнөөл нь ялангуяа нутгийн уугуул иргэдийн хүүхдүүд, үндэсний цөөнхийн хүүхдүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, гамшиг болон уур амьсгалын өөрчлөлтөд өртөмтгий газарт амьдардаг хүүхдүүд гэх мэт зарим тодорхой бүлгийн хүүхдүүдэд илүү их аюул учруулж болзошгүй юм. Засгийн газрууд бүлэг хоорондын тэгш бус байдлын талаар сайтар мэдэхийн тулд мэдээлэл цуглуулж, тэдгээрийг шийдвэрлэх тодорхой арга хэмжээ авах хэрэгтэй. Засгийн газрууд хүрээлэн буй орчны асуудлаар арга хэмжээ авахдаа хүүхдэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх явдалд онцгой анхаарах шаардлагатай.





3-р зүйл

Хүүхдийн эрх ашгийг дээдлэх

Хүрээлэн буй орчин болон уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаар аливаа шийдвэр гаргахдаа тэдгээр нь хүүхдүүдэд хэрхэн нөлөөлөх, өнөөдөр өсөж торниж буй болон ирээдүйд өсөж торних хүүхдүүдийн сайн сайхан байдал, хөгжлийг хэрхэн дэмжих талаар засгийн газрууд анхаарч үзэх ёстой.

6-р зүйл

Эсэн мэнд төрөх, өсөх, хөгжих эрх

Хүүхэд эрүүл, аюулгүй орчинд амьдрах, өсөж торних, хөгжих, шаардагдах дэмжлэгийг авах эрхтэй. Бохирдол, хар тугалгад өртөх зэрэг хүрээлэн буй орчинд учирч буй хор хөнөөлийн улмаас тэдний амь нас хэзээ ч эрсдэлд орох ёсгүй.



12-р зүйл

Дуу хоолойгоо хүргэх эрх

Хүүхдүүд хүрээлэн буй орчин, уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой асуудлуудаар санал бодлоо илэрхийлэх эрхтэй бөгөөд насанд хүрэгчид тэдний санал бодлыг нухацтайгаар авч үзэх ёстой. Засгийн газрууд хүрээлэн буй орчин болон уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаар шийдвэр гаргахдаа хүүхдүүдийг оролцуулж, хүүхдүүдийн санаа бодлыг хэрхэн авч үзсэн талаараа хүүхдүүдэд мэдээлэл өгөх шаардлагатай.



13, 15-р зүйл

Үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх, тайван замаар хуран цуглах эрх

Хүний эрхийг хамгаалагчийн хувиар хүүхдүүд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ төлөө байнга тэмцдэг. Хүүхдүүд мөн найз нөхөд, хамт олонтойгоо цагийг хамт өнгөрөөж, мэдээлэл солилцон, санаа бодлоо хуваалцдаг. Засгийн газрууд хүүхдүүдэд эрх мэдэл олгосон, аюулгүй орон зайг ханган өгч, үзэл бодлоо илэрхийлэхэд нь дэмжлэг үзүүлэх учиртай. Засгийн газар хүний эрхийг хамгаалагч хүүхдүүдийг хамгаалах хууль батлах шаардлагатай.





13, 17-р зүйл

Мэдээлэл авах эрх

Засгийн газрууд нь гаргаж буй буй төлөвлөгөө, шийдвэрүүд болон хүүхдүүд өөрсдөө авч хэрэгжүүлж болох арга хэмжээ гэх мэт хүрээлэн буй орчин, уур амьсгалтай холбоотой тодорхой, үнэн зөв мэдээллийг хүүхдүүдэд хүртээмжтэй байлгах шаардлагатай. Мэдээллийг төрөл бүрийн арга хэлбэрээр дамжуулж, харилцан адилгүй насны, өөр өөр нөхцөлд байдалд байгаа хүүхдүүд ойлгох нөхцлийг бүрдүүлэх хэрэгтэй.

19-р зүйл

Бүх төрлийн хүчирхийлээс ангид байх эрх

Хүрээлэн буй орчинд учирч буй хор хөнөөл, уур амьсгалын өөрчлөлт нь тогтворгүй нөхцөл байдал, мөргөлдөөн, тэгш бус байдлыг бий болгож, улмаар хүүхдүүдийг бие махбодийн болон сэтгэлзүйн хүчирхийлэлд өртөх эрсдлийг нэмэгдүүлдэг. Засгийн газрууд хүүхдэд зориулсан үйлчилгээнд хөрөнгө оруулалт хийж, хүчирхийллийн суурь шалтгааныг арилгах замаар хүүхдийг хамгаалахад илүү их хүчин чармайлт гаргах шаардлагатай.



19-р зүйл

Эрүүл байх эрх

Уур амьсгалын өөрчлөлт, бохирдол, эрүүл бус экосистем, биологийн олон янз байдал алдагдах явдал зэрэг нь хүүхдийн бие махбодийн болон сэтгэцийн эрүүл мэндэд нөлөөлөх ёсгүй. Эрүүл мэндийн асуудал тулгарсан тохиолдолд хүүхэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах боломжтой¹⁶ байх ёстой.



26, 27-р зүйл

Нийгмийн халамж хүртэх, амьжиргааны зохистой түвшинд амьдрах эрх

Хүүхдэд аюулгүй хоол хүнс, цэвэр ус, зохистой орон байр, амьдрах болон өсөж том болоход нь шаардлагатай материаллаг зүйлс хүртээмжтэй байх учиртай. Засгийн газрууд хүүхдүүдийг ядуу эсвэл аюулгүй бус нөхцөлд амьдрахгүй байх нөхцлийг бүрдүүлэх шаардлагатай.

28, 29-р зүйл

Боловсрол эзэмших эрх

Хүүхдэд хүрээлэн буй орчны талаарх үнэн зөв мэдлэг, боловсролыг тэдний ойлгож чадах арга хэлбэрээр олгох ёстой. Хүрээлэн буй орчны боловсрол нь хүүхдийг хүрээлэн буй орчинтойгоо холбогдох, түүнд хүндэтгэлтэй хандахад дэмжлэг үзүүлэх учиртай. Хүүхдийн сурч боловсорч буй газар нь хүрээлэн буй орчинд учирч буй хор хөнөөлөөс хамгаалагдсан аюулгүй байх ёстой.



30-р зүйл

Нутгийн уугуул иргэдийн хүүхдүүд болон үндэсний цөөнхийн хүүхдүүдийн эрх

Нутгийн уугуул иргэдийн хүүхдүүд болон үндэстний цөөнхийн хүүхдүүдийн амьдрал, оршин тогтнол, соёл ахуйн дадал нь ихэвчлэн байгаль орчинтойгоо нарийн холбоотой байдаг. Засгийн газрууд тэдний эрхийг хамгаалж, тэдний хүрээлэн буй орчинтой холбогдуулан гаргаж буй бүх шийдвэрт хүүхдүүдийг оролцуулах шаардлагатай.

31-р зүйл

Амрах, тоглох эрх

Хүүхдүүд цэвэр, аюулгүй газар тоглож, идэвхтэй байж, байгаль орчинтойгоо холбогдох боломжтой байх ёстой. Засгийн газрууд хүүхдүүд очиж болох шинэ орчин, газруудыг төлөвлөхдөө хүүхдүүд хаана, хэрхэн тоглож, амарч болохыг анхаарч үзэх хэрэгтэй.

Цэвэр, эрүүл, тогтвортой орчинд амьдрах эрх

Хүүхэд цэвэр, эрүүл, тогтвортой орчинд амьдрах эрхтэй болохыг Хороо тайлбарлаж байна. Хүний бүхий л эрхээ эдлэхийн тулд хүүхдэд цэвэр орчин хэрэгтэй. Хүүхдэд цэвэр агаар, ус, аюулгүй уур амьсгал, эрүүл экосистем, биологийн олон янз байдал, эрүүл хоол хүнс, бохирдолгүй орчин хүртээмжтэй байх ёстой.



Хүүхдийн эрх, байгаль орчны асуудлаархи ерөнхий тайлбар 26



НҮБ-ын Хүүхдийн эрхийн хороо: “Уур амьсгалын өөрчлөлтөд онцгой анхаарал хандуулсан Хүүхдийн эрх, байгаль орчны асуудлаархи ерөнхий тайлбар #26” (2023)

Жилээс жилд өсөн нэмэгдэж байгаа уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэл, аюулыг шийдэхийн тулд Хүүхдийн эрхийн тухай конвенцийг соёрхон баталсан 196 улс дараахь арга хэмжээг хэрэгжүүлэхийг уриалж байна.

Үүнд нэн яаралтай авах арга хэмжээ:

- Нүүрс, газрын тос, байгалийн хийн ашиглалтаас сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр рүү шилжих
- Агаарын чанарыг сайжруулах
- Цэвэр усны хүртээмжийг нэмэгдүүлэх
- Эрүүл хүнс үйлдвэрлэхийн тулд хөдөө аж ахуй, загасны аж ахуйг эрчимжүүлж, биологийн олон янз байдлыг хамгаалах.

Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, түүнд дасан зохицох арга хэмжээнд хүүхэд гол цөм нь байх ёстой.

Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах арга хэмжээний үр дүнг өнөөдрийн хүүхдүүд үзэж чадахгүй, оройтсон байх болно. Учир нь одоогоос 2050 хүртэл хугацаанд бий болох дэлхийн дулаарал, түүний үр дагавар нь хүн төрөлхтний аль хэдийнээ агаар мандалд ялгаруулсан хүлэмжийн хийний үр дагавар юм. Нэн шаардлагатай нийгмийн үйлчилгээг уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, гамшгийн эрсдэлийг бууруулах, хор хохирлыг барагдуулах, эрт зарлан мэдээлэх, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлбэл дэлхийн хүүхдүүдийн амьдралд өөрчлөлтийг бий болгож чадна.

Бидэнд тулгамдаж буй дараах асуудлыг шийдэхийн тулд нэн яаралтай арга хэмжээ авах шаардлагатай.



Нэн шаардлагатай нийгмийн суурь үйлчилгээ нь өөрчлөгдөж буй уур амьсгал, давтамж нь улам нэмэгдэж буй гамшигт үзэгдэл, хүрээлэн буй орчинд учирч буй бохирдол, хор хөнөөлд их эмзэг.



Бид ирээдүй хойч үеийн хүүхдүүддээ ирээдүйн боловсрол, ур чадварыг олгож, эх дэлхийдээ ээлтэй иргэн, ногоон ирээдүйг бүтээсэн манлайлагч болох боломжийг бий болгох ёстой.



Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, ирээдүйд учирч болох аюул, эрсдэлээс сэргийлэх, тогтвортой ирээдүйг бий болгох амлалтдаа дэлхий нийт хүрч чадахгүй байна.



БАЯРЛАЛАА